## Үзүүлэлтүүд:
Монголын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явц

**Зорилт 1. Ядуурлыг бууруулах**
2008 – хүн амын 35.2% нь амьдралын баталгаажих түвшнээс доогуур амьдарч байна
2015 оны зорилт: 18%

**Зорилт 2. Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших**
91.4 % анхан шатны боловсрол эзэмшсэн
2015 оны зорилт: 100%

**Зорилт 3. Хүйсийн тэгш байдал**
Үндэсний парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь 3.9% байна
2015 оны зорилт: 30.0%

**Зорилт 4. Хүүхдийн эндэгдлийг бууруулах**
2000 – 1000 амьд төрөлт тутамд 5-с доошхи насны хүүхдийн эндэгдэл 44.5
2007 - 1000 амьд төрөлт тутамд 5-с доошхи насны хүүхдийн эндэгдэл 23.2

**Зорилт 5. Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах**
2000 - 1000 амьд төрөлт тутамд эхийн эндэгдэл 166.3
2007 - - 1000 амьд төрөлт тутамд эхийн эндэгдэл 67.2

**Зорилт 6. Бэлгийн замын халдварт өвчин, хүний дархлал хомсдлын вирус, сүрьеэтэй тэмцэх**
100000 хүн тутамд сүрьеэ өвчний тархалт 185.3
2015 оны зорилт: 100.0

**Зорилт 7. Байгаль орчны тогтвортой байдлыг хангах**
Хүн амын 60.8% нь баталгаат ундны усаар хангагдаж чадаагүй
2015 оны зорилт: 40.0%

**Зорилт 8. Дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх**
Нийгмийн суурь үйлчилгээнд үзүүлсэн ХАЁТ-ийн хувь хэмжээ 3.28%
2015 оны зорилт: 5.0%

**Зорилт 9. Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх**
Хүний хөгжлийн индекс 0.700

*Эх сурвалж: МХЗ-уудын хэрэгжилт – 2007 оны тайлан, Үндэсний Статистикийн тайлан 2007 он.*

## МОНГОЛД НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА - 2008

| Үйл ажиллагааны чиглэл | Хандивлагч байгууллага | Нийт төсөв Ам.доллар * |
|---|---|---|
| **Ардчилсан засаглалыг хөгжүүлэх**<br>• Авлигын эсрэг<br>• Ерөнхийлөгчийн тамгын газрын чадавхийг бэхжүүлэх<br>• Монгол улсын Сонгуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх<br>• Хүний эрх, Ардчилсан засаглалын тухай 9-р МХЗ-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх<br>• Орон нутгийн засаглал<br>• Шударга ёс, Хүний эрхийн хүртээмж<br>• Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Хамтарсан Хөтөлбөр<br>• Шударга, Төрийн үйлчилгээг бэхжүүлэх | НҮБ-ын Ардчилалын Сан (НҮБ-ын АС) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) | 1.411 |
| **МХЗ-уудыг биелүүлэх ба ядуурлыг бууруулах**<br>• Ядуурал, Ажил эрхлэлтийг дэмжих судалгаа<br>• Монголд үйлдвэрлэл хөгжүүлэх<br>• Далайд гарцгүй, хөгжиж буй орон болох Монгол улсын МХЗ-уудаа биелүүлэхэд хэрэгтэй онцлог хэрэгцээнд дэмжлэг үзүүлэх<br>• Үндэсний ядуурал, МХЗ-уудын мониторинг, үнэлэхэд тусламж үзүүлэх<br>• Хөгжлийн хамтын ажиллагааны үр ашигийг нэмэгдүүлэх | Солонгос, Япон дахь НҮБХХ | 1.739 |
| **Тогтвортой хөгжил, хямралаас урьдчилан сэргийлэх ба сэргээн босгоход эрчим хүч, хүрээлэн буй орчныг хөгжүүлэх**<br>• Алтай Саяны бүрэн хөтөлбөр<br>• Хүрээлэн буй орчны засаглалыг бэхжүүлэх<br>• Монголд цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент<br>• Гамшигийг бууруулах ба түүний менежментийн тогтолцоог бэхжүүлэх<br>• Ус, усны эрүүл ахуй хамтарсан хөтөлбөр | Недерланд, Люксембург, Стокхолмын Олон улсын усны институт, Дэлхийн байгаль орчны сан, НҮБХХ. | 2.261 |
| **Нийт** | | 5.410 |

*Эх сурвалж: 2009 оны 3-р сарын 18, НҮБХХ-ын Atlas мэдээллийн сан.

**НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр,**
**НҮБ- ын гудамж 12, Сүхбаатар дүүрэг,**
**Улаанбаатар.**

**www.undp.mn**

Зураг: НҮБХХ Монгол

2009 оны 4-р сар

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр

# ОДОО БИД……

## Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр






# МОНГОЛ ДАХЬ НҮБ-ЫН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

### НҮБХХ – Мянганы Хөгжлийн Зорилтуудаа Биелүүлэхэд Монгол Улсад Тусалж байна.

*НҮБХХ нь Монгол улсыг ядуурлаа 2015 он гэхэд 1990 оныхтой харьцуулахад 2 дахин бууруулах зорилготой үндэсний Мянганы Хөгжлийн Зорилтуудаа (МХЗ) хэрэгжүүлэхэд тулгарч буй онцлог асуудлуудаа шийдвэрлэхэд нь дэмжлэг үзүүлэх Монголын Засгийн газрын итгэмжит түнш юм.*

Монгол улс нь дэлхийн хамгийн ариун дагшин, хүн амын нягтаршил багатай орнуудын нэг юм. өргөн уудам газар нутаг нь бэлчээр, ой мод, уул толгод, өргөн дэлгэр тал, элсэн цөл гэсэн олон янзын тогтоцтой. Хөдөөгийн ихэнх Монголчууд малчид ба хүнсээ авах, орлоготой байх гол эх үүсвэр нь мал юм. Сүүлийн жилүүдэд нийт газар нутгийн 70 орчим хувь доройтол цөлжилтөд өртөж байгаа явдалд хүний үйл ажиллагаа ихээхэн нөлөөлж байна. Монгол улс далайд гарцгүй байдаг нь тээвэр, дамжин өнгөрөх зардлыг их хэмжээгээр нэмэгдүүлж, худалдааны өрсөлдөх чадварыг хязгаарлаж, хөгжлийн томоохон асуудалтай нүүр тулж байна.

Монгол улс нь залуучуудын орон ба 2.6 сая хүн амын 77% нь 35-с доош насны залуучууд юм. Монголын ард түмэн ардчилал, зах зээлийн эдийн засагт 1990 онд зоригтойгоор шилжин орсон ба ЗГ нь дэлхийд анх удаа ардчилал, хүний эрхийг бэхжүүлэх 9-р МХЗ-ыг боловсруулж баталсан. Лондонд төвтэй Далайн чанадын Хөгжлийн Институтийн хийсэн судалгаагаар чадавхийг бэхжүүлэхдээ олон улсын хөгжлийн хамгийн үр дүнтэй ажилладаг байгууллага бол НҮБХХ гэж зарласан билээ. НҮБХХ нь хүнийг эрх мэдэлжүүлэх, туршлага мэдлэгээ хуваалцах, анхан шатнаас эхлэн ЗГ хүртэлх нийгмийн бүх түвшний чадавхийг бэхжүүлэх замаар есөн МХЗ-уудаа биелүүлэхэд нь, мөн түүнчлэн шударга ёс, эрх тэгш байдлын зарчимд тулгуурласан сайн засаглалын бат бэх сууриа тавихад нь Монгол улсад тусалдаг.

## Хүний хөгжлийг дэмжих

НҮБХХ нь хөдөө орон нутгийн 3000 гаруй эрэгтэй, эмэгтэйчүүдэд жижиг, дунд бизнес эрхлэн, түүнийгээ өргөжүүлэн хөгжүүлэх замаар ядуурлаас гарах сонголтоо хийхэд нь дэмжлэг үзүүлсэн. Сургалт, жижиг зээл, бизнесийн бусад үйлчилгээнд хамрагдсанаар тэдний борлуулалтын орлого 30%-иар өсөж, 400 ажлын байрыг шинээр бий болгосон билээ. 2006 онд нээлтээ хийсэн "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" санаачлага нь дотоодын онцлог бүтээгдэхүүнээ брэнд болгон хөгжүүлж, үндэсний болон олон улсын зах зээлд гаргах боломжийг олгосон.

Нэн ядуу, эмзэг бүлгийнхний хэрэгцээнд нийцэх бодлогыг боловсруулах үндэс болсон бодит баримтад суурилсан Монголын анхны "ядуурлын зураг"-ийг гаргахад бид тусалж ажилласан. Үүний дээр 21 аймаг, 9 дүүрэгт байрлах аймаг, нийслэлийн иргэний бүртгэлийн байгууллагуудыг холбосон иргэний бүртгэлийн анхны он-лайн систем байгуулагдсанаар Монголын хүн бүрийг бүртгэж, ядуурлыг анхан шатанд нь тодорхойлох боломжтой болсон.

Мөн түүнчлэн бид Монголын хүний хөгжлийн асуудлыг тодорхойлж, дүн шинжилгээ хийдэг, хүн төвт бодлогыг дэмждэг Үндэсний Хүний Хөгжлийн Тайланг бэлтгэж, тараахад ЗГ-тай хамтран ажилладаг.

НҮБ-ын бусад агентлагуудтай ойр, хамтын ажиллагаатай байж МХЗ-той холбоотой бодлогыг боловсруулах хэрэгжүүлэхэд Монголын ЗГ-т тусалж ажилладаг. Төрийн бус байгууллага, академи, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийг хамарч өргөн оролцоотой боловсруулагдсан Үндэсний МХЗ-ын тайлан нь үндэсний зорилтуудаа хүрэх үйл явцаа үнэлж, хянахад томоохон ач холбогдлоо өгсөн. Зургаан анхдагч аймаг дахь орон нутгийн байгууллагууд өөрсдийн хөгжилд учирч буй тулгамдсан асуудлаа үнэлэх, орон нутгийнхаа МХЗ, бодлого, төлөвлөгөөгөө тодорхойлох чадвартай болсон.



Газрын тогтвортой менежментийн талаар зөвлөгөө өгч байгаа нь.

Энэ үйл явц нь МХЗ-той холбоотой мэдээллийг цуглуулдаг, тараадаг DevInfo системийг байгуулснаар улам сайжирсан билээ. МХЗ-ыг хэрэгжүүлэхэд зарцуулах жилийн төсөв, төлөвлөгөөнд хангалттай эх үүсвэрийг хуваарилах Яамны албан тушаалтны чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж ирлээ.

Дэлхийн туршлага солилцох, сүлжээ үйл ажиллагаагаар дамжуулан бид Монгол улсын олон улсын зах зээлд гарах чадамжийг нэмэгдүүлж байна. 2007 онд Монгол улс НҮБХХ-ийн тусламжтайгаар далайд гарцгүй орнуудын худалдаа ба худалдааны арга хэмжээний тухай дэлхийн уулзалтыг зохион байгуулснаар Далайд гарцгүй орнуудын дунд Монгол улсын тэргүүлэх чадвар сайжирсаар байна.

## Байгалийн үнэт нөөцийг хамгаалах

НҮБХХ нь Монголын ЗГ-тай хамтран олон төрөл зүйл бүхий эмзэг байгалийн экосистемийг зөв удирдаж, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны хамгаалал ба ядуурлыг бууруулах үүрэг хариуцлагатай нэгтгэж ажиллахад орон нутгийн байгууллагуудыг чадавхижуулсан.

12 аймгийн 100 гаруй малчдын бүлэг өөрсдийн газраа ашиглах төлөвлөгөөгөө хамтран боловсруулж, ус, ой, бэлчээрийн удирдлагын шилдэг туршлагаа баяжуулсаар байна. Тэд мал аж ахуйн бүтээмжээ ихэсгэн орлогоо нэмэгдүүлэн ажиллаж байна.

Бид ЗГ-тай дараах байдлаар хамтран ажиллаж байна:

- Байгаль орчны хууль, дүрэм болон холбогдох байгууллагын үйл ажиллагаанд хийх үр дүнгийн үнэлгээнд нарийн хяналт тавих явдлыг дэмжих замаар Байгаль орчныг хамгаалах хууль зүйн тогтолцоог бэхжүүлэх.
- Холбогдох ЗГ-ын байгууллагын ажилтнуудыг байгаль орчны бодлогыг амьдралд хэрэгжүүлэх, түүний үр дүнд хяналт тавих тухай сургалтанд хамруулах.
- Бэлчээрийн газрын тухай хуулийн төслийг боловсруулах, бэлчээрийн газрын шинэ хэлтсийг чиглэлийн Яаманд байгуулахад дэмжлэг үзүүлэх.
- Улсын Онцгой Байдлын Газрын техникийн ба хүний нөөцийг бүрдүүлж, бэхжүүлэх. Дотоодын аврах багийг орчин үеийн тоног төхөөрөмж, хамгаалалтын хувцсаар хангах, байгалийн болон хүний хүчин зүйлээр үүсэх гамшигийн үеийн ажиллагаанд бэлтгэгдэж, илүү үр дүнтэй хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулах.
- Гамшигаас хамгаалах тухай шинэ хуулийг боловсруулах, Гамшигийн эрсдлийг бууруулах үндэсний үйл ажиллагааны цар хүрээ, Цаг агаарын эрсдлийн менежментийн үндэсний стратегийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх.
- Цаг агаарын өөрчлөлт, био төрөл зүйл, цөлжилтийн тухай байгаль орчны үндсэн гурван конвенцийн дагуу үйл ажиллагааг дэмжиж, хэрэгжилтийг тайлагнахад туслах.

## Хүнийг эрх мэдэлжүүлэх, хүний эрхийг хамгаалах

Бид Монгол улсын ардчилсан нийгэмд шилжсэн шилжилтийг дэмжих зорилгоор Монгол улсын 9 дэхь МХЗ-ыг биелүүлэхэд чиглэсэн ардчилал, хүний эрхийн түвшинг хэмжих, хянах системийг бий болгоход ЗГ, иргэний нийгэмтэй хамтран ажилласан.

Сонгогчдод боловсрол олгох хөтөлбөрийг улс даяар хэрэгжүүлж, 1150 гаруй сургагчид сонгогчдын сонгуулийн оролцоог огцом нэмэгдүүлсэн ба мэдээлэл сайтай сонгууль болоход хувь нэмрээ оруулсан.

Сонгуулийн ерөнхий хороонд стратеги төлөвлөгөөний талаар шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшүүлэх замаар шударга, ил тод сонгууль явуулах үйл явцыг сайжруулсан.

Тодотгон хэлэхэд, НҮБХХ нь авилгатай тэмцэх гол байгууллага юм. Бид Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, ба түүний үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Авилагийн эсрэг шинэ хуулийг боловсруулахад ЗГ-тай хамтран ажилласан ба Бие даасан Авлигын эсрэг агентлагийг байгуулахад, түүний чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийн тулд Нэг цэгийн үйлчилгээний төвийн програм хангамжийг боловсруулахад тусалсан болно. Бид ЗГ-ын албан тушаалтнуудад зориулсан ёс зүй, шударга ёсны сургалтад тусламж үзүүлсэн.




Сул дорой бүлгийн эрхийг хамгаалах зорилгоор Монгол улсын бүх аймаг, дүүргүүдэд хууль ёсны төлбөрөө барагдуулах чадваргүй хүмүүст хүрч үйлчлэх боломжтой, хуулийн төрөл бүрийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг Хууль зүйн тусламжийн 30 төвийг байгуулахад дэмжлэг үзүүлсэн.

НҮБХХ-ийн буцалтгүй тусламжтайгаар дөрвөн аймгийн тэргүүлэгчид орон нутгийнхаа хэрэгцээнд нийцсэн 97 шинэ санаачлага төслийг боловсруулж хэрэгжүүлсэн. Орон нутгийн иргэдийн санал хүсэлтийн дагуу эдгээр төслүүдэд нийтийн усанд орох газар, унды усны нөөц, гудамжны гэрэлтүүлэг, гүүр, явган хүний зам, засмал зам, хүүхдийн паркийн нөхцлийг сайжруулах төслүүдээс эхлэн хогийн менежмент, интернет үйлчилгээ, бэлчээрийн газрын тогтвортой менежмент хийх зэрэг төслүүд багтсан.

Жендерийн ялгавартай хүчирхийллийг төгсгөл болгох үйл ажиллагааны хүрээнд бид эмэгтэйчүүдийг хүчирхийлэн дарамтлах гол шалтгааныг тодорхойлох судалгааг явуулахад НҮБ-ын Агентлагуудтай нэгдэж ажилласан ба гэмт хэрэгтний зан байдлыг өөрчлөх хөтөлбөрийг боловсруулахад ЗГ-т тусалсан.

*НҮБХХ нь зучин жил гаруй Монголд ажилласан туршлага дээрээ үндэслэн улс орныг хариуцлагатай, хариу өгдөг ЗГ-тай, МХЗ-уудаа биелүүлэхийн төлөө, бүгдийг хамарсан хөгжлийн төлөө хамтдаа зүтгэдэг урам зоригтой, эрх мэдэлтэй ард түмэн бүхий хөгжлийн үлгэр жишээ орон болоход туслах гол суваг болон ажилладаг. Цаашдаа ч манай үйл ажиллагаа МХЗ-д суурилсан Үндэсний Хөгжлийн Стратегийн хэрэгжилтийг дэмжих замаар өөрчлөлт шинэчлэлийн ЗГ-ийн хөтөлбөрт дэмжлэг үзүүлэхэд чиглэж ажиллана.*